



**НИЙСЛЭЛИЙН
ХӨДӨЛМӨРИЙН БИРЖИЙН ЗАХИРЛЫН
ТУШААЛ**

2008 оны 05 сарын 08 өдөр

Дугаар 11

Улаанбаатар хот


**ЗУУЧЛАЛЫН ГЭРЭЭ БАЙГУУЛАХ
ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ**

ТУШААХ НЬ:


Нэг. Нийслэлийн нутаг дэвсгэрт байрлан үйл ажиллагаа явуулж буй байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс сул чөлөөтэй ажлын байрны захиалгыг авч, дотоодын ажил хайгч иргэдийг зуучлан хамтран ажиллах гэрээ байгуулах болон хураамжийн хэмжээг тогтоох үед мөрдөх журмыг хавсралтаар баталсугай.

Хоёр. Журмыг 2008 оны 5 дугаар сарын 8-наас эхлэн дагаж мөрдсүгэй.

Гурав. Журмын хэрэгжилтэд байнгын хяналт тавьж ажиллахыг нягтлан бодогч /О.Одхүү/, мэргэжилтэн /Ч.Бадамханд/ нарт үүрэг болгосугай.



Б.БАТБААТАР



/My doc/NKhBirj/A4/

0500021

Нийслэлийн Хөдөлмөрийн биржийн
захирлын 2008 оны 05 дугаар сарын 08
өдрийн 10 дугаар тушаалын хавсралт

ЗУУЧЛАЛЫН ГЭРЭЭ БАЙГУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журам нь гадаад болон дотоодын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж байгууллагуудтай "Монгол улсын Үндсэн хууль", "Хөдөлмөрийн тухай хууль", "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль"- ийн хүрээнд гэрээ байгуулж, тухайн байгууллагад байгаа сул чөлөөтэй ажлын байрны захиалгыг авч дотоодын ажил хайгч иргэдийг зуучлан хамтран ажиллах, хураамжийн хэмжээг тогтоож өгөхөд оршино.

1.2. Гэрээ байгуулах үйлчилгээний хураамжийг байгууллагын захирлын тушаалаар баталж, зарцуулалтыг тооцоход энэхүү журмыг мөрдлөг болгоно.

Хоёр. Гэрээ байгуулах зөвшөөрөл авах

2.1. Ажиллах хүчин авахаар гэрээ байгуулах аж ахуйн нэгж байгууллага, хувь хүмүүс нь гэрээ байгуулахаас 3 хоногийн өмнө Нийслэлийн Хөдөлмөрийн биржид албан бичгээр хүсэлтээ гаргана. Албан бичигт объектын байршил, харилцах хүний утасны дугаар, ямар мэргэжлийн хичнээн хүн авах хүсэлтэй байгаагаа нэгбүрчлэн бичиж, аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар, тусгай зөвшөөрлийн хуулбар, харьяа дүүргийн Татварын газраас татвар төлөгчийн тодорхойлолт зэргийг авч хавсаргасан байна.

2.2. Ирүүлсэн хүсэлтийг судалж үзсэний дараа тарифын дагуу хураамжийг авч, гэрээг 2 хувь үйлдэж, баталгаажуулна.

2.3. Үйлчилгээний хураамжийн үнэ 5000 /таван мянган/ төгрөг байна. Төлбөрийг бэлнээр авч, мөнгө тушаасан баримтыг олгоно.

Гурав. Үйлчилгээний төлбөр авах, түүний зарцуулалт, хяналт тавих

3.1. Гэрээ байгуулснаас олсон орлогыг Нийслэлийн Хөдөлмөрийн биржийн захирлын хяналт дор бичиг хэргийн зардал /бичгийн цаас, хавтас авах, принтерийн хор цэнэглэх, хувилах зардал/, хөдөлмөрийн зах зээлийн талаарх уралдаан тэмцээн зохиох, ном товхимол хэвлүүлэх гэх мэт ажлуудыг санхүүжүүлэхэд зарцуулна.

3.2. Орсон орлого, зардалд тавих хяналтыг байгууллагын нягтлан бодох хариуцна.

НИЙСЛЭЛИЙН ХӨДӨЛМӨРИЙН БИРЖ